

ТӨРИЙН ХИЛИЙН БОДЛОГЫН ОРЧИН ҮЕИЙН СТРАТЕГИ

Б.Жавхлан

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын акедимийн 8012 дугаар дамжааны суралцагч, Магистрант, хошууч

Товч агуулга: Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжууд нь Төрийн хилийн бодлого, орчин үеийн стратегид нийцсэн талаар санал дүгнэлт дэвшүүлэхэд оршино.

Түлхүүр үгс: Төрийн хилийн бодлого, Бүсчилсэн хил хамгаалалт, Хилийн бодлогын стратеги.

Оршил: Улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, улсын хил хамгаалах бодлогын зорилго, агуулга нь үндсэндээ нэгдмэл шинжтэй зүй тогтол хуультай үзэгдэл болохыг манай өвөг дээдэс нээж хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Энэ санааг орчин үеийн ойлголттой харьцуулвал улс орноо хамгаалах бодлого, үйлдэл нь улс орныг бүхэлд нь хамарсан онол, практик байсан бөгөөд мөн чанартаа стратегийн мэдлэг, ойлголтын үндэс болж хэрэгжсэнээс гадна Монголд тэр тусмаа олон зуун жилийн түүхэн улбаатай нь харагдаж байна.

Орчин үед төрийн хилийн бодлого нь олон улсын эрх зүйн бодлого, зохицуулалтад чухал байр эзэлж, бие даасан шинж, агуулгатай үүрэг гүйцэтгэж байна.

Энэхүү бодлогод “Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон Улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана” гэсэн чухал заалт байдаг.

Төрийн хилийн бодлого нь эдийн засгийн шинжлэх ухаан буюу түүнийг тодорхой хэлбэрт оруулан

тусгасан эдийн засгийн бодлогын хүрээнд тодорхой байр эзэлжээ. Төрийн хилийн бодлогод “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах”-ыг зааж өгчээ.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтууд эцсийн эцэст нийгэм эдийн засгийн байдал, бодит арга хэмжээнээс ихээхэн шалтгаалдаг зүй тогтолтой байна.

Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэгч үндсэн субъектээр Засгийн газрын агентлагийн статустай Хил Хамгаалах Байгууллага байхыг хуулиар тодорхойлжээ.

Түүний мөн чанар, агуулга, чиглэл, хэрэгжүүлэх механизмыг Улсын хилийн тухай хуульд тодорхойлсон байдаг.

Орчин үед төрөөс хилийн талаар баримтлах бодлого зайлшгүй байхыг шаардаж байгаа олон зүй тогтол байна.

Агуулга: Бодлогын тухай ерөнхий ойлголт

Стратегийн тухай ерөнхий ойлголт

Төрийн хилийн бодлого орчин үеийн стратеги
Бодлогын тухай ерөнхий ойлголт

Бодлого гэж юу вэ ?

Төрөөс баримтлах бодлого, бодлогын үзэл баримтлал гэх зэргээр Монгол Улсын төрөөс батлан гаргасан маш олон “Бодлого”-ын гэх баримт бичгүүд байна.

Гэхдээ бодлого гэж чухам юуг хэлдэг, тэр нь чухам юунд хэрэгтэй бодлогын мөн чанар, онцлог, түүнд тавигдах шаардлага, бодлогыг хэрхэн боловсруулж гаргадаг талаар тодорхойлсон нэгдсэн ойлголт хараахан олдохгүй байна.

Бодлого, төрийн бодлого, бодлого стратеги, бодлого төлөвлөгөө, төрөөс баримтлах бодлого, мөнгөний бодлого, холын бодлого, алсын бодлого, гадаад дотоод бодлого, бодлого тодорхойлох, намын бодлого, хатуу бодлого, бодлогын баримт бичиг гэх мэтээр **“Бодлого”** хэмээх ойлголтыг гарган ирж эрх зүйн болон удирдлагын баримт бичигт түгээмэл хэрэглэж байна.

Бодлого гэдэг үг нь Монгол Улсын үндсэн хуульд 10, Улсын Их Хурлын тухай хуульд 41 удаа орсон бөгөөд нийгэм эдийн засгийн салбар бүрт төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, тэдгээрийг боловсронгуй болгох, хэрэгжилтэд нь хяналт тавих талаар хуульчилж, түүнийгээ нийгмийг удирдан чиглүүлэх үйл ажиллагааны үндэс болгон тавьсан байна.

Иймд **“Бодлого”** гэдэг нь үйл ажиллагааны чиглэлийг заасан, ажиллах зарчмыг тодорхойлсон баримт бичиг болох нь харагдаж байна.

Бодлого гэдэг ухагдахуунд төр барих, засаглах, нийгмийн амьдралын хүрээний бүхийл асуудлаар төрөөс явуулах удирдлагыг хэлж байна.

Энэ нь бодлого гэдэгт төрөөс явуулах үйл ажиллагааны үзэл бодлын цогц ороод зогсохгүй, явуулж байгаа үйл ажиллагаа нь нэгэн адил хамаарах өргөн утгыг илэрхийлдэг болохыг харуулж байна.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хангагдаж, Улсын хил халдашгүй дархан байхаар тус улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудад маш тодорхой тусгагдаж эрх зүйн бүрэн бүтэн баталгаатай болсон байна.

Монгол Улсын төрөөс Улсын хилийн талаар баримтлах бодлогыг тусгайлан гаргаж түүнд нийцүүлэн Улсын хилийн тухай хууль гарч, практикт бүтээлчээр хэрэгжиж байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, зорилтыг дэс дараатай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж жил бүр хэрэгжилт гүйцэтгэлийг гарган ажиллаж байна.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг юм.

Хилийн талаар баримтлах бодлого нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх МУ-ын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн юм.

Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын тусгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг

энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана гэсэн байна.

Стратегийн тухай ерөнхий ойлголт

Монгол Улсын хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратеги нь төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн Улсын хилийн тухай шинжлэх ухаан, түүний эрх зүй, онол-практикийн үндсийг бүрдүүлэх хилийн урлагийн дээд хэлбэр болдог юм.

Монгол Улсын үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын хууль, үзэл баримтлалд Улсын хилийн талаар тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд тухайн стратегийн үүсэл хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй байхыг өнөөгийн цаг үе, нөхцөл байдал зүй ёсоор шаардаж байна.

Тайлбар толь бичигт “Стратеги” гэдэг нь Грек үг бөгөөд “Strategos”- цэргийн хүчин, “Ago”- залах жолоодох хөтлөх гэсэн агуулгатай, альч улс гүрэн хэрэглэж болох **цэргийн урлагийн бүрэлдэхүүн** хэсэг бөгөөд түрэмгийллийг няцаахад улс орон зэвсэгт хүчнийг бэлтгэх, дайн, стратегийн цар хэмжээний цэргийн ажиллагааг төлөвлөн явуулах онол практикийг багтаасан тэргүүлэх салбар мөн юм.

Стратегийн онол нь дайны зүй тогтол, шинж чанар, түүнийг явуулах аргыг судалж, дайн стратегийн операцыг төлөвлөх, бэлтгэн явуулах онолын үндсийг боловсруулдаг.

Цэргийн стратеги нь практик үйл ажиллагааны салбар байдгийн хувьд:

Зэвсэгт хүчний стратегийн үүргийг болон түүнийг биелүүлэхэд шаардагдах хүч хэрэгслийг тодорхойлох, түрэмгийллийг няцаахад улс орны хүн ам, эдийн засаг, нутаг дэвсгэр, зэвсэгт хүчнийг бэлтгэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, стратегийн операцыг төлөвлөх, зэвсэгт

хүчний дэлгэн байгуулалтыг зохион байгуулах ба дайны явцад түүнийг удирдах, болзошгүй дайсны дайн, стратегийн операци явуулах боломжийг судлах зэрэг асуудлууд хамаардаг.

Улс гүрэн оршин тогтноход эерэг, сөргөөр нөлөөлөх маш олон хүчин зүйлүүд байдаг. Тэр бүхнийг төрөөс объектив мэдлэгийн хүрээнд мэргэжлийн стратегчдийн хүч бололцоог ашиглан нарийвчлан судлан шинжилж бодлогоо зөв бүтээлчээр тодорхойлохоос гадна хэрэгжүүлэх стратегийнхаа бэлтгэл явцын төлөвийг урьдаас харж улс орны хэмжээнд төлөвлөж бэлтгэхгүй бол Улс орон тодорхой аюул тохиолдсон нөхцөлд орших, эс оршихын дэнсэн дээр тулж очдог байна.

Аль ч Улсын оршин тогтнолд Улсын хил онцгой чухал байр эзэлдэг.

Улсын хил нь үргэлжид ямарч нөхцөлд хөршлөх хоёр талын Улсын эрх барих дээд байгууллагын түвшинд харилцан зөвшилцөж, хамтарч байгуулсан гэрээгээр тодорхойлогдож, тогтоогддог бөгөөд тэрхүү эрх зүй нь тухайн улсын бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг давхар тодорхойлдог хүчин, үнэт зүйл болдог зүй тогтолтой байна.

Энэ бүхэн Улс орныг бүхэлд нь батлан хамгаалах цэргийн стратеги, хил хязгаарын аюулгүй байдал буюу хилийн бодлогын стратегийн нэгдмэл шинж, бас тус тусын онцлогийг илэрхийлдэг объектив шинжтэй бодит хэм хэмжээний илэрхийлэл болж байгаа юм.

Стратеги нь тодорхой зорилго, зорилтууд, цаг хугацаа, орон зайн хүрээ хязгаарт явагддаг онцлогтой.

Хүннү гүрэн манай эрины өмнө хоёр зуугаад жилийн тэртээ төрт улсаа байгуулаад өөрийн улсын нутаг дэвсгэрийг өмнөд хэсэгт эртний Цагаан

хэрэм, өрнөд чиглэлд Иль, Тарвагатайн нуруу, умард талд Байгаль далайн дээд хормой, Дорно хэсэгт Их хянганы ноён оргил нуруу давсан хязгаарын хүрээнд багтаасан байдаг тухай гадаад дотоодын эрдэмтэд хөдлөшгүй баримтаар нотолж тогтоосон байдаг.

Энэ орон зайд Монголчууд төрийн хуулиар баталгаажсан улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд юуны урьд хилийн бодлогын стратегид онцлон анхаарч байсан билээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг тууштай хадгалж, улс, ард түмний язгуур эрх ашгийг хангаж, хамгаалах цар хүрээнд хэрэгжсэн стратеги нь, гадаад, дотоод, объектив, субъектив, бодит ба бодит бус маш олон зүйлээс шалтгаалж олон хэлбэр шинжийг хадгалсан стратегийн зорилтуудыг манай ахмад үе нийгмийн хөгжлийн бүх үе шатуудад амжилттай хэрэгжүүлж ирсэнийг хөдлөшгүй баримт түүх гэрчилдэг.

Эндээс үүдээд хилийн орон зай гэдэг нь хөршлөх улсуудын хил, хил орчмын нутаг дэвсгэр дээр улсын хилийн хүчин зүйлүүд, мөн эдгээр улсуудын улс төр, нийгэм, эдийн засгийн янз бүрийн шинж байдалтай уялдан гарч ирсэн үзэгдэл үйлдлийг багтаасан нийгмийн онцгой салбар хэсэг гэж үзэж болно.

ТӨРИЙН ХИЛИЙН БОДЛОГО, ОРЧИН ҮЕИЙН СТРАТЕГИ

Төрийн хилийн бодлогын стратеги нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлэх нэг төрлийн механизм бөгөөд Үндэсний аюулгүй байдлыг улсын хил, хязгаарт хангахад тэргүүлэх байр эзэлдэг, түүнд олон яам, байгууллагууд харилцан ажиллагаатайгаар нэгэн зорилго, эрх ашгийн дор цогц, олон арга

хэмжээнүүдийг хэрэгжүүлж байж үр дүнд хүрдэг гэж ойлгож болно.

Төрийн хилийн бодлогын стратегийн зорилго нь дараах гурван төрөлд ангилагдаж байна. Үүнд:

Улс төрийн зорилго: Улсын хилийг хууль бусаар өөрчлөх оролдлого, санаархал гаргуулахгүй байх, зэвсэг, галт хэрэгсэл, сэм дамын худалдаа, хууль бус цагаачлал, хүний болон хар тамхины наймаа, төрөл бүрийн гэмт этгээдийг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, хил дээр гарч болзошгүй сүйрлийн шинжтэй үйлдлээс сэргийлэх, гаргахгүй байх, хилийн болон хил орчмын дэглэмийг чанд сахиулах замаар Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах.

Нийгэм, Эдийн засгийн зорилго: Улсын хил орчмын хязгаар нутагт төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хамгаалах, ялангуяа эдийн засаг экологи зэрэг Үндэсний аюулгүй байдлын бүх элементийг тухайн хэсэгт хангаж нийгэм эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх.

Батлан хамгаалах буюу цэргийн зорилго: Хөрш улсын хил орчмын бүс нутагт цэргийн бүлэглэл, цэргийн давуу хүчин бий болгохгүй байх нөхцөл бүрдүүлэх, хил дээр гарсан зэвсэгт будлиан, халдлага, түрэмгийллийн шинжтэй аюул, заналхийлэлд хүргэхгүйгээр шийдвэртэй таслан зогсоож, гарсан үйлдлийг бут цохих, хилээ сэргээх, хилчдээр хилээ манах, хамгаалах зарчмыг тууштай баримтлах.

Стратегийн зорилго, зорилтууд

Улсын хилийн хардашгүй дархан байдлыг хадгалж, улсын хил, хязгаарт төр, нийгэм иргэдийн эрх ашгийг хамгаалах нь хилийн талаар Төрөөс баримтлах бодлогын амин сүнс юм. Монгол улсын Их хурлаас 2002 онд

батлагдсан 20 дугаар тогтоолд **“Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн”**, Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ гэж тэмдэглэжээ.

Энэ нь хил хамгаалах бодлогын стратегийн үндсэн зорилго агуулгыг тодорхойлох үндэс, хэрэгжүүлэх боломжийг олгож байна.

Улсын хилийн талаар Төрөөс баримтлах бодлого нь Монгол улсын үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, бусад хууль тогтоомжид тусгагдсан боловч Монгол улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг тусгайд нь батлан гаргасан явдал онцгой ач холбогдолтой юм. Ийм үзэлд бодолд үндэслэгдсэн хилийн тухай бодлогын стратегийг дэлхийн олон улс, гүрэн улсын хилийн талаар баримтлах **“хилийн бодлогын стратеги”** гэж хоршин хэрэглэдэг практик байгаа бөгөөд манай улсын хэмжээнд ч энэ зарчмыг баримталж хэвшүүлэхэд боломжтой гэж үзэж байна.

Стратеги гэдэг бол цэргийн хэргийн хүрэн дэх үндсэн зорилгыг хангах цэргийн урлагийн дээд хэлбэр агуулсан онол ба практик мөн болохыг би урьд дурьдсан. Харин хилийн бодлогын стратегийн агуулгыг урьд ерөнхийд нь илэрхийлсэн бөгөөд монгол улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах чиглэл, хүч хэрэгсэл, түүнчлэн үйл ажиллагааны арга хэлбэрийн урлагт тулгуурлаж, төрийн, эрх барих дээд байгууллагаас тодорхойлж томъёологдсон тодорхой

систем гэж ойлгож хандах нь онцгой ач холбогдолтой.

Төрийн хилийн бодлогын стратеги нь:

Төлөвлөсөн стратегийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны агуулга нь судалгаа, шинжилгээнд үндэслэгдсэн байдаг учраас шинжлэх ухаан гэсэн ойлголтод багтдаг. Үүгээрээ онолын үндэслэл болдог.

Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх субъектүүд (төр, засаг, захиргаа, хууль хэрэгжүүлэх ба сахиулах байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэд гэх мэт)-ийн өмнө дэвшигдсэн зорилгот хүрэх бүх боломжийг төр бүрдүүлдэг бөгөөд субъектүүд тэдгээрийг дүүрэн ашиглаж, байнга өөрчлөгдөж байдаг нөхцөл байдлыг зөв үнэлж, уялдуулсан чадварлаг үйл ажиллагааны шинж байдал буюу ур чадварыг илэрхийлсэн урлагаар дамжиж агуулга мөн чанар нь илэрдэг. Энэ хоёр үзүүлэлт нь стратегийн онол ба практикийн агуулгыг илэрхийлж байгаа учраас тус тусд нь ялгаатай авч үзэх шаардлага гарна.

Нэгдүгээрт:

Хилийн бодлогын стратегийн онолын боловсруулалтад дараах үндсэн асуудлуудад анхаарал хандуулах шаардлага гарна.

Стратегийн үүрэг, зорилгыг тодорхойлж, стратегийн боловсруулалтыг төлөвлөхөд нийгэм, улс төр, цэргийн ба тусгай зориулалтын ямар зайлшгүй шаардлагууд байгааг танин мэдэх, үүний үр дүнд цэгцэрсэн ойлголттой болох хэрэгтэй.

Энэ бүхнийг төрийн хилийн бодлоготой нягт уялдаа холбоотой авч үзэх шаардлагатай

Хилийн бодлогын стратегийн мөн чанар, түүнчлэн үйл ажиллагааны

үе шатыг системчлэн нээж, харуулах нь их чухал

Хилийн талаарх Төрийн бодлогын стратегийн нийгэм, улс төр, цэрэг тусгай чиглэлийг үүрэг зориулалтын үндэслэлийг бодитойгоор тодорхойлох

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах стратегд хилийн стратегийн эзлэх байр, ролийг оновчтой тодорхойлох

Хилийн бодлогын стратегийн шинж байдал, хамрах хүрээ, хязгаар, зорилго, зорилтууд, чиглэл, зарчим, арга хэлбэрийг тодорхойлж тогтоох

Хилийн бодлогын стратегийн олон улсын хүрээнд анхаарах асуудлуудад улс төр, дипломат, эрх зүй, эдийн засаг, батлан хамгаалалт, тагнуул, сөрөг тагнуул, гааль, байгаль хамгаалалт, ариун цэвэр хорио цээр, засаг захиргаа, мэдээлэл, хүнийн нөөц, түүнчлэн Төрийн хилийн бодлогын стратегийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлдэг бүх субъектүүдийн чиг үүрэгтэй холбогдсон асуудлуудыг багтаан төлөвлөх ба практикт хэрэгжүүлэх ажиллагааг ч энд багтаана.

ДҮГНЭЛТ

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хадгалж, улсын хил, хязгаарт төр, нийгэм иргэдийн эрх ашгийг хамгаалах нь хилийн талаар Төрөөс баримтлах бодлогын амин сүнс нь юм.

Тэгвэл Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжууд нь Төрийн хилийн бодлого, орчин үеийн стратеги юм.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого

Гамшгаас хамгаалах бодлого

Ш.Арвай “МУ-ын төрөөс Улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог” 2015